

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/202/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/119
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 32,293.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 38,614.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэн, санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөр 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,426,422.65</u>	<u>325,122,520.83</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,722,710.67	245,492,122.68
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,722,710.67	245,492,122.68
3121	Төгрөг	4,722,710.67	245,492,122.68
31211	Төрийн сангийн харилцах	4,602,710.67	245,492,122.68
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	120,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,703,711.98	79,630,398.15
351	Түүхий эд материал	27,703,711.98	79,630,398.15
35110	Тусгай зориулалттай материал	10,955,295.45	53,508,670.62
35130	Эм боох материал	16,748,416.53	26,121,727.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>328,550,814.84</u>	<u>333,663,507.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,550,814.84	333,663,507.93
392	Биет хөрөнгө	312,408,814.84	317,521,507.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	243,514,269.00	243,514,269.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,557,328.82	-48,482,421.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,480,000.00	118,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-74,082,888.70	-85,422,222.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	179,265,563.70	196,882,505.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-121,417,165.78	-130,081,226.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,506,832.95	31,089,177.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,210,123.51	-9,288,230.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,900.00	64,900.00
39217	Ном	844,756.00	844,756.00
393	Биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
39301	Программ хангамж	634,000.00	634,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-634,000.00	-634,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,142,000.00	16,142,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>360,977,237.49</u>	<u>658,786,028.76</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>360,977,237.49</u>	<u>658,786,028.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	360,977,237.49	658,786,028.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,267,812.78	311,267,812.78
51101	Өмч: - төрийн	295,125,812.78	295,125,812.78
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	16,142,000.00	16,142,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-81,900,863.92	215,907,927.35
51210	Өмнөх үеийн үр дүн	-81,900,863.92	-81,900,863.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	297,808,791.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,610,288.63	131,610,288.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>360,977,237.49</u>	<u>658,786,028.76</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	905,416,682.82	1,091,827,661.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	305,981,927.82	81,408,501.46
120	Нийтлэг татварын бус орлого	276,001,537.82	81,408,501.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	276,001,537.82	81,408,501.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	835,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	275,166,537.82	81,408,501.46
122	Тусламжийн орлого	29,980,390.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	29,980,390.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	157,024,055.00	1,010,419,160.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,410,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,120,755.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,120,755.00	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,903,300.00	45,903,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,903,300.00	45,903,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	964,265,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	964,265,860.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	682,559,093.40	752,587,939.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,559,093.40	752,587,939.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	668,588,012.40	738,594,470.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,374,217.84	414,449,756.62
210101	Үндсэн цалин	222,134,113.22	260,398,410.40
210102	Нэмэгдэл	83,902,704.62	109,501,288.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,263,000.00	6,062,000.00
210104	Урамшуулал	35,074,400.00	38,488,057.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,000,887.49	56,460,577.27
210201	Тэтгэврийн даатгал	34,018,903.13	42,045,385.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,011,876.56	3,932,792.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,392,701.26	3,075,674.05
210204	Ажилгүйдлийн даатгал	507,036.95	669,529.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,070,369.59	6,737,195.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,632,219.00	30,729,831.00
210301	Гэрэл, цахилгаан	1,974,975.00	4,222,680.00
210302	Түлш, халаалт	26,297,244.00	26,177,151.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,064,392.00	55,621,825.00
210401	Бичиг хэрэг	1,999,300.00	3,688,860.00
210402	Тээвэр, шатахуун	36,067,592.00	44,249,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,997,500.00	2,768,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,615,010.00

2105	Нормативт зардал	52,850,509.91	78,755,611.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,355,009.91	67,760,011.00
210502	Хоол, хүнс	9,495,500.00	10,995,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,540,200.00	18,758,267.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	502,700.00	1,396,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,737,500.00	6,131,967.10
210604	Урсгал засвар	1,300,000.00	11,230,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	2,926,000.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	2,926,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,625,586.16	80,892,602.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,600,700.29	15,097,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,024,885.87	65,795,082.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,971,081.00	13,993,469.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,971,081.00	13,993,469.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	13,971,081.00	13,993,469.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>222,857,589.42</u>	<u>339,239,721.77</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	225,390,284.81	41,430,930.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	225,390,284.81	41,430,930.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-225,390,284.81	-41,430,930.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-2,532,695.39</u>	<u>297,808,791.27</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	630,250,145.00	1,010,419,160.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,815,390.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	835,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	835,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	835,000.00	00.00
122	Тусламжийн орлого	29,980,390.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	29,980,390.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	599,434,755.00	1,010,419,160.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,410,700.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,120,755.00	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,120,755.00	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,903,300.00	45,903,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,903,300.00	45,903,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	964,265,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	964,265,860.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	622,977,434.33	769,649,747.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	622,977,434.33	769,649,747.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,998,353.33	755,656,278.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,147,698.71	414,449,756.62
210101	Үндсэн цалин	221,907,594.09	260,398,410.40
210102	Нэмэгдэл	83,902,704.62	109,501,288.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,263,000.00	6,062,000.00
210104	Урамшуулал	35,074,400.00	38,488,057.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,227,406.62	56,460,577.27
210201	Тэтгэврийн даатгал	33,205,613.26	42,087,281.12
210202	Тэтгэмжийн даатгал	3,298,215.56	3,932,792.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,621,772.26	3,075,674.05
210204	Ажилгүйдлийн даатгал	554,708.95	669,529.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,547,096.59	6,695,299.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,632,219.00	30,729,831.00
210301	Гэрэл, цахилгаан	1,974,975.00	4,222,680.00
210302	Түлш, халаалт	26,297,244.00	26,177,151.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,470,892.00	62,710,825.00
210401	Бичиг хэрэг	1,999,300.00	3,688,860.00
210402	Тээвэр, шатахуун	26,474,092.00	44,249,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,997,500.00	2,988,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	9,484,010.00

2105	Нормативт зардал	26,034,882.00	88,101,322.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,539,382.00	77,105,722.00
210502	Хоол, хүнс	9,495,500.00	10,995,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,096,700.00	80,632,947.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,699,200.00	41,445,780.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,097,500.00	29,401,967.10
210604	Урсгал засвар	1,300,000.00	9,785,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	2,926,000.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	2,926,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,888,555.00	19,645,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,888,555.00	19,645,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,979,081.00	13,993,469.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,971,081.00	13,993,469.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,272,710.67</u>	<u>240,769,412.01</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,550,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,550,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,550,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,550,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,550,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,722,710.67	240,769,412.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	4,722,710.67
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,722,710.67	245,492,122.68

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	-81,900,863.92	360,977,237.49
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	-81,900,863.92	360,977,237.49
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	-81,900,863.92	360,977,237.49
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	297,808,791.27	297,808,791.27
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,267,812.78	131,610,288.63	215,907,927.35	658,786,028.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	969,223,900.00	755,656,278.99	213,567,621.01	77.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,223,900.00	755,656,278.99	213,567,621.01	77.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,223,900.00	755,656,278.99	213,567,621.01	77.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,524,100.00	414,449,756.62	106,074,343.38	79.62
210101	Үндсэн цалин	259,124,600.00	260,398,410.40	(1,273,810.40)	100.49
210102	Нэмэгдэл	171,466,500.00	109,501,288.62	61,965,211.38	63.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,552,000.00	6,062,000.00	490,000.00	92.52
210104	Урамшуулал	83,381,000.00	38,488,057.60	44,892,942.40	46.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,708,400.00	56,460,577.27	9,247,822.73	85.93
210201	Тэтгэврийн даатгал	47,881,800.00	42,087,281.12	5,794,518.88	87.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,456,900.00	3,932,792.58	524,107.42	88.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,565,200.00	3,075,674.05	489,525.95	86.27
210204	Ажилгүйдлийн даатгал	891,200.00	669,529.97	221,670.03	75.13
210205	Эрүүл мэндийн даатгал	8,913,300.00	6,695,299.55	2,218,000.45	75.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,603,300.00	30,729,831.00	13,873,469.00	68.90
210301	Гэрэл, цахилгаан	5,056,800.00	4,222,680.00	834,120.00	83.50
210302	Түлш, халаалт	39,183,500.00	26,177,151.00	13,006,349.00	66.81
210303	Цэвэр, бохир ус	363,000.00	330,000.00	33,000.00	90.91
2104	Хангамж, бараа материалын зардал	80,755,000.00	62,710,825.00	18,044,175.00	77.66
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	3,688,860.00	111,140.00	97.08
210402	Тээвэр, шатахуун	44,250,000.00	44,249,955.00	45.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,300,000.00	700,000.00	76.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,988,000.00	12,000.00	99.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,705,000.00	9,484,010.00	17,220,990.00	35.51
2105	Норматив зардал	120,150,000.00	88,101,322.00	32,048,678.00	73.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,650,000.00	77,105,722.00	23,544,278.00	76.61
210502	Хоол, хүнс	19,500,000.00	10,995,600.00	8,504,400.00	56.39
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,586,600.00	80,632,947.10	25,953,652.90	75.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,100,000.00	41,445,780.00	5,654,220.00	88.00
210602	Тавилга	48,626,600.00	29,401,967.10	19,224,632.90	60.46
210604	Урсгал засвар	10,860,000.00	9,785,200.00	1,074,800.00	90.10
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,926,000.00	74,000.00	97.53
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,926,000.00	74,000.00	97.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,896,500.00	19,645,020.00	8,251,480.00	70.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,896,500.00	19,645,020.00	8,251,480.00	70.42
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	969,223,900.00	1,015,021,870.67	(45,797,970.67)	104.73

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,123,900.00	45,903,300.00	2,220,600.00	95.39
132001	Орон нутгийн төсвөөс	48,123,900.00	45,903,300.00	2,220,600.00	95.39
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	733,459,000.00	732,061,100.00	1,397,900.00	99.81
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	733,459,000.00	732,061,100.00	1,397,900.00	99.81
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	187,641,000.00	237,057,470.67	(49,416,470.67)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	187,641,000.00	237,057,470.67	(49,416,470.67)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,602,710.67	(4,602,710.67)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	245,492,122.68	(245,492,122.68)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.00	26.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төв нь зорилгоо “Хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, бие бялдрын өв тэгш хөгжлийг хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг, ёс зүйтэй орчинд, цаг алдалгүй, жигд хүртээмжтэй, чанартай, соёлтой үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам ”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 297,808.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,722.71	245,492.12	240,769.41
Авлага	-	-	-
Бараа материал	27,703.71	79,630.39	51,926.68
Үндсэн хөрөнгө	328,550.81	333,663.51	5,112.70
Нийт хөрөнгийн дүн	360,977.23	658,786.02	297,808.79
Өглөг	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	295,125.81	295,125.81	-
Эздийн өмчийн бусад хэсэг	16,142.00	16,142.00	-
Хуримтлагдсан үр дүн	(81,900.86)	215,907.93	297,808.79
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,610.28	131,610.28	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	360,977.23	658,786.02	297,808.79

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 240,769.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 551,926.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 42,794.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,112.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 32,293.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 38,614.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 48,123.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 733,459.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 187,641.0 мянган төгрөг, нийт 969,223.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 969,223.9 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 48,123.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 733,459.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 187,641.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 45,903.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 964,265.9 мянган төгрөг, нийт 1,010,419.2 мянган төгрөгийн санхүүжилт

төвлөрснөөс урсгал үйл ажиллагаанд 769,649.7 мянган төгрөгийг зарцуулж, 245,492.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 755,656.3 мянган төгрөг буюу 77.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 106,074.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13,873.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 18,044.2 мянган төгрөг, норматив зардал 32,048.7 мянган төгрөг, томилолт зочны зардал 74.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,251.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80111-Төрийн байгууллагын тогтмол зардал	45,903.30	45,903.30	-	100.00
1.2	80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	468,499.60	381,890.79	86,608.81	81.51
1.3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	264,960.30	234,329.10	30,631.20	88.44
1.4	83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	187,641.00	107,406.56	80,234.44	57.24
Дүн		967,004.20	769,529.75	197,474.45	79.58

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 917050.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,755.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаас 75 хувиар буюу 10,316.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 106,074.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13,873.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 18,044.2 мянган төгрөг, норматив зардал 32,048.7 мянган төгрөг, томилолт зочны зардал 74.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,251.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 148 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 148 мэдээллээс 127 мэдээллийг хугацаандаа, 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 145,979.8 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 80,976.3 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 2,242.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1 албан шаардлага, 78,733.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарч байна. Хэрэгжилт 91.7 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Төлбөрийн акт	1	2,242.9	1	2,242.9	100.0
Зөвлөмж	4	78,733.4	3	78,733.4	75.0
Нийт дүн	6	80,976.3	5	80,976.3	91.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,286.6 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 30,286.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчил илрээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 7 харилцагч байгууллагын 30,286.6 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 7 харилцагч байгууллагын 30,286.6 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	30,286.6	-	-	-	-	1	30,286.6	-	-	-	-
Дүн	1	30,286.6	-	-	-	-	1	30,286.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 148 мэдээллээс 127 мэдээллийг хугацаандаа, 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn